

12-Р САРЫН МЭДЭЭ



МЭДЭЭ

УР ЧАДВАР ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТУУД БОЛОН ҮДИЙН ЦАЙНЫ ЯРИЛЦЛАГА

ШИНЭ ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БИЧИЛ ТӨСЛҮҮД

УР ЧАДВАР ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТУУД БОЛОН ҮДИЙН ЦАЙНЫ ЯРИЛЦЛАГА

Өнгөрсөн хугацаанд Эмэгтэйчүүдийн Манлайллын Хөтөлбөрийн (ЭМХ) оролцогчид манлайллын ур чадварыг дээшлүүлэх жендэрийн сургалт, тогтвортой хөгжил, манлайлал, харилцаа зэрэг сургалтуудад хамрагдсан. ЭМХ-ийн оролцогчид зочин илтгэгчдээс их зүйлс сурч, урам зориг авч байгаагаа илэрхийлэв.

“Энэхүү хөтөлбөрийн нэг хэсэг болсондоо сэтгэл дүүрэн байна. Сургалтууд маш сайн, үр өгөөжтэй болж байна.” - ЭМХ-ийн оролцогч Баттөмөрийн Буяндэлгэр.

Хөтөлбөрийн бас нэгэн чухал хэсэг нь үдийн цайны ярилцлага юм. Хууль зүйн яамны дэд сайд Баярсайханы Солонгоо оролцогчидтой өөрийн туршлагыг үдийн зоог барин хуваалцав. Үдийн цайны ярилцлага нь оролцогчдын манлайллын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ ХӨТӨЛБӨРИЙН МЭДЭЭ



Хөтөлбөр хэрэгжих хугацаанд дараах зочидтой уулзалт хийсэн. Үүнд:

- Доктор С. Оюун, Даян дэлхийн ногоон сангийн Гадаад хэргийн асуудал хариуцсан захирал
- Уолтер Женкинс, АНУ дахь Зориг сангийн ерөнхийлөгч

ШИНЭ ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

12-р сарын 7-ны өдөр шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд Австралийн Элчин Сайдын Яам, Монгол-Австралийн Нийгэмлэг, Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөр, Зориг сан, Монгол дахь Австралийн Худалдааны Танхимын төлөөлөл, Эмэгтэйчүүдийн Манлайллыг Хөгжүүлэх богино хугацааны сургалтын 2021 оны төгсөгчид болон Эмэгтэйчүүдийн Манлайлал хөтөлбөрийн оролцогч нар оролцлоо. Монгол улсад суугаа Австралийн ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Дэвид Престон, Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн захирал Лүндэнгийн Энхтүвшин болон Монгол-Австралийн Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Цэгмэдийн Лут-Очир нар тус арга хэмжээг нээж үг хэлэв.

Зочид хөгжмийн тоглолт, стэнд-ап комеди үзэж, сугалаатай бэлгийн тэмцээнд оролцон шинэ жилийн баяраа тэмдэглэв.



НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БИЧИЛ ТӨСЛҮҮД

Мөн тус хөтөлбөрийн онцгой ач холбогдолтой нэг хэсэг нь оролцогчдын хэрэгжүүлдэг нийгэмд чиглэсэн төслүүд байдаг. Энэ удаагийн оролцогчид өөрсдийн сонирхлоороо 4 багт хуваагдан доорх 4 төслийг хэрэгжүүлэхээр бэлдэж байна. Үүнд:

Community Development төсөл нь Сонгино-хайрхан дүүргийн 34-р хорооны ахлах сургуулийн охид, эмэгтэйчүүдэд чиглэсэн шинэ ур чадвар, мэдлэг олгох цуврал сургалт явуулахын зэрэгцээ тэдэнд зориулсан нийтийн хөгжлийн төв байгуулах замаар хувь хүний өсөлт, хөгжилд дэмжлэг үзүүлнэ. Төслийн ашиг хүртэгчид нь уг хөгжлийн төвд нийтийн угаалга, хатаалга, халуун усны үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжтой байхын зэрэгцээ тэдэнд зориулан суурилуулсан интернет, компьютер, принтер, мөн мэдлэгийн буланг тогтмол ашиглах боломж бүрдэнэ.

“Эмэгтэйчүүдийн манлайлал хөтөлбөрт хамрагдсанаар өөрөө хөгжихөөс гадна нийгэмд чиглэсэн төслөөр дамжуулан бусад эмэгтэйчүүдийг ч мөн хөгжүүлэх боломж бүрдэнэ гэхээр их сайхан санагдаж байгаа.” Охид, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, дэмжих төслийн багийн гишүүд

Mental Health төсөл нь “Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв”-д суралцаж буй өсвөр насны сурагчдын сэтгэцийн эрүүл мэнд болон нөхөн үржихүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой. Төслийн хүрээнд оюутнуудад сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой сургалт зохион байгуулахаас гадна сургуулийн сэтгэл зүйчтэй уулзах боломжтой бясалгал болон амралтын өрөөг бүрэн тохижуулах зорилготой байгаа юм.

“Бид Эмэгтэйчүүдийн Манлайлал хөтөлбөрийн 8 дахь элсэлтийн оролцогчдоор шалгарсандаа тун таатай байна. Манлайлал болон хувь хүний хөгжлийн цогц хөтөлбөрийн оролцогчид болох #MeforMyself багийн гишүүдийн хувьд бид өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлэхээр зорьж байна.” - #MeforMyself багийн гишүүд

НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БИЧИЛ ТӨСЛҮҮД

Checkmate төсөл нь Улаанбаатар хотын иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин хомс байдаг тул шатар, сагсан бөмбөг тоглох боломжтой орчныг бүрдүүлэх зорилготой юм. Эдгээр тоглоомыг бага насны хүүхдүүд болон ахмад насны хүмүүс ч тоглох боломжтой тул сонгохоор болсон.

“Энэхүү хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн манлайлал гэхээсээ илүү эрэгтэй эмэгтэй хүмүүс өөр өөрийн онцлогийг ашиглан хэрхэн тухайн ажиллаж байгаа салбартаа, албан байгууллагадаа мөн өөрийн гэр бүлдээ эерэг өөрчлөлт, оновчтой шийдлийг гаргаж ирэх талаар юм.” - Checkmate багийн гишүүд

A*READ төсөл нь Монголд аутизм болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тэдний унших чадвар, хэл яриа, нийгэм-харилцааны зэрэг чухал суурь чадваруудыг хөгжүүлэх агуулгатай ном сурах бичгүүдийг мэргэжлийн байгууллагатай хамтран тэдгээр хүүхдүүдэд тохиромжтой хэлбэрээр тусгайлан хөгжүүлж (adapted books) дижитал хэлбэрээр, хүртээмжтэй байдлаар хүргэхийг зорьж байна.

*“Аутизм бол хөгжлийн бэрхшээл биш, харин өөр нэгэн чадвар юм гэж Стюарт Дункан хэлсэн байдаг. Хэрвээ бид харагдах өнгөц байдлаар нь дүгнэлгүйгээр хүн бүрд өөрийн гэсэн чадвар чадамж бий, гагцхүү тэр чадварт анхаарлаа хандуулан хөгжихөд нь тусалж, хувь нэмрээ оруулах нь бидний зорилго болсон.” - A*READ багийн гишүүд.*